

ХИС-ИЙН ОЮУТАН ТӨГСГӨХ ЖУРАМ

Нэг. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

“ХИС-ийн бакалаврын сургалтын журам” болон “Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам”-ын дагуу суралцаж зохих шаардлагыг хангасан оюутанд дээд боловсролын зэрэг, төгсөлтийн баримт бичиг, энгэрийн тэмдэг олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. ТӨГСӨГЧДӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Төгсөгч нь ХИС-д зохих журмын дагуу ХИС-ийн захирлын тушаалаар элссэн байна.
2. Төгсөгч нь суралцаж буй мэргэжлийнхээ хувьд хамгийн сүүлд мөрдөгдөж буй сургалтын төлөвлөгөөний дагуузаавал судлах болон сонгон судлах хичээлийн 120-иос доошгүй багц цагийг амжилттай цуглуулж, бакалаврын зэргийн шаардлагуудыг хангасан байна.
3. Төгсөгч нь сургалтын болон бусад хэлбэрийн санхүүгийн төлбөрийн тооцоогүй байна.
4. Төгсөгч төгсөлтийн шалгалт, бакалаврын төгсөлтийн ажлын хамгаалалтанд амжилттай дүн үзүүлсэн байна.
5. Төгсөлтийн шалгалт, бакалаврын төгсөлтийн ажлын хамгаалалтанд 90-ээс дээш үнэлгээтэй, суралцсан хугацааны үнэлгээний голч дүн (GPA) 3.7-гоос дээш голч дүнтэй төгсөгчдөд ОНЦГОЙЛОХ диплом олгоно.

Гурав. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТ

1. Төгсөлтийн шалгалтыг “ХИС-ийн төгсөлтийн шалгалтын журам”-ыг баримтлан явуулна.
2. Энэхүү дүрмийн 2-р зүйл дэх болзолыг хангасан оюутнуудыг салбар сургууль, тэнхим, сургалтын албатай хамтран сургалтын албаны системийн төгсөх оюутны жагсаалтанд оруулж, төгсөлтийн комисстой хамтран ажиллана.
3. Төгсөлтийн комиссын шийдвэрээр салбар сургууль, тэнхимийн бүрэлдэхүүнтэй хяналтын баг томилж, төгсөх оюутны жагсаалттай танилцаж, сурлагын дүн бусад холбогдох материалуудтай тухайн хичээлийн жилийн 2-р улирлын 15-16 дахь 7 хоногт багтаан хөндлөнгийн шалгалт хийнэ.
4. Уг хяналтын багийн бүрэлдэхүүнийг салбар сургуулиуд харилцан солилцож байгуулах ба шалгалтын баримт бичиг түүнтэй холбоотой тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
5. Төгсөлтийн шалгалт болон бакалаврын төгсөлтийн ажил хамгаалах оюутны нэрсийг захирлын тушаалаар батлуулж, төгсөлтийн шалгалтын комисст хүлээлгэн өгнө.
6. Төгсөлтийн шалгалтанд орох эрх авсан оюутан хүндэтгэн үзэх шалтгаанаар шалгалтаа өгч чадахгүй болсон тохиолдолд энэ тухай шалгалтын комисс протоколд тэмдэглэх ба үүнийг

үндэслэн дараагийн улирлын шалгалтанд хамруулж болно. Энэ эрх нь захирлын тушаал гарсанаас хойш 5 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Дөрөв. ТӨГСӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ

- 4.1. Тухайн мэргэжлийн зэргийн сургалтыг амжилттай дүүргэж зохих шаардлагуудыг хангасан оюутанд төгсөлтийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болон диплом, энгэрийн тэмдгийг ХИС-ийн захирлын тушаалаар олгоно.
- 4.2. Тухайн мэргэжлийн зэргийн диплом нь төрийн захиргааны дээд шатны байгууллагаас батлагдсан загварын дагуу холбогдох албан тушаалтнуудын гарын үсэг, диплом, бүртгэлийн дугаартай байх ба монгол-англи хувилбараар хэвлэгдэж, ХИС-ийн захирлын тамга тэмдэгээр баталгаажсан байна.
- 4.3. Тухайн мэргэжлийн зэргийн диплом нь хавсралттай байх ба хавсралтанд нийт суралцсан хугацаанд судалсан хичээлүүдийн багц цаг, сурлагын үнэлгээ, голч дүн оноог бичихээс гадна тухайн үеийн дүрэм журамд нийцүүлэн бусад бичиглэлийг хийж болно. Хавсралтыг ХИС-ийн захирал, салбар сургуулийн захирал, сургалтын албаны дарга нарын гарын үсэг, тамга /тэмдэг/-ээр баталгаажуулж, диплом, бүртгэлийн дугаартай байна.
- 4.4. Төгсөгчдөд энгэрийн тэмдэг олгоно.
- 4.5. Төгсөлтийн баримт бичгийг засварлах буюу хуурамчаар үйлдвэл зохих хуулийн хариуцлагыг хүлээнэ.
- 4.6 Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд архивын материалыг үндэслэн нөхөн диплом олгох бөгөөд энэ нь тусгай журмаар зохицуулагдана. Харин комиссын буруутай үйл ажиллагааны улмаас диплом дахин олгох асуудлыг тухайн үед мөрдөгдөж буй дүрэм /журамд/ нийцүүлэн шийдвэрлэнэ.

Тав. ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛ

- 5.1. ХИС-ийн төгсөгчдөд мэргэжлийн зэргийн диплом, энгэрийн тэмдгийг ёслол төгөлдөр хүндэтгэлтэйгээр гардуулна. Ёслолын арга хэмжээнд захирлын тушаалыг уншиж сонсоно.
- 5.2. Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааг төгсөлтийн комиссын ерөнхий нарийн бичиг, салбар комисстой хамтран зохион байгуулна.
- 5.3. Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааг ХИС-ийн захирал нээж үг хэлнэ. Үүний дараа тухайн жилийн шилдэг оюутан үг хэлнэ.
- 5.4. Төгсөлтийн үйл ажиллагааны танхимд төгсөгчдийн эцэг эх, найз нөхдийн төлөөлөл 4 хүртэлх хүн оролцох боломжтой.
- 5.5. Төгсөлтийн ёслолын арга хэмжээг олон нийтийн радио, телевиз, сонин хэвлэлээр сурталчилж болно. Сурталчлах арга хэмжээг төгсөлтийн шалгалтын салбар комисс зохион байгуулна.
- 5.6. Төгсөлтийн ёслолын арга хэмжээнд төгсөгчид сургуулийн өнгө төрхийг илтгэсэн ХИС-ийн “Төгсөгчдийн ёслолын өмсгөл”-тэй оролцоно.

5.7. Боловсролын зэргийн баримт бичиг, энгэрийн тэмдэг, ёслолын өмсгөлтэй холбоотой гарах зардлыг “Ёслолын өмсгөл түрээслэх гэрээ” -нд заагдсан хугацаанд холбогдох дансанд байршуулна.